



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

МЭДЭЭЛЭЛ ТЕХНОЛОГИЙН ҮНДЭСНИЙ ПАРК ТӨҮГ-ЫН 2020 ОНЫ
САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

АУДИТЫН КОД: САГ-2021/22/СТА-ТӨААТҮГ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Аудитын хоёрдугаар газрын захирал, тэргүүлэх
Аудитор: Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер Г.Гүнжидмаа
Утас: 261885 Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn
Ахлах Аудитор А.Даваадорж
Утас: 261885 Цахим хаяг: davaadorja@audit.gov.mn
Аудитыг гүйцэтгэсэн: "Стандарт дүгнэлт аудит" ХХК
Утас: 70111721 Цахим хаяг: info@sda-audit.mn

Улаанбаатар хот
2021 он

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Товчилсон үгийн жагсаалт

СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар
ТӨААТҮГ	Төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани

Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт	3-4
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5-6
2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан.....	7
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан.....	8
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	9-10
2.5 Аудит хийсэн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний тайлан.....	11
3.Аудитын тайлан.....	12
3.1. Ерөнхий зүйл.....	12
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй.....	12
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт.....	12-13
3.4. Материаллаг байдал.....	13
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд.....	13-14
3.6. Зорилтот түвшний төлөвлөлт, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	14-16
3.7. Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн, үйл ажиллагаа.....	16
3.8. Шилэн дансны мэдээлэл.....	16
3.9. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	16
3.10. Аудитын илрүүлэлт.....	16-17
3.11. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд.....	17
4. Менежментийн захидал.....	18
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	19



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас: 26-04-37, Факс: 51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

МЭДЭЭЛЭЛ ТЕХНОЛОГИЙН
ҮНДЭСНИЙ ПАРК ТӨААТҮГ-ЫН
ЗАХИРАЛ Э.ЦОГТГЭРЭЛ ТАНАА

2021.03.15 № 07/868
танай _____ -ны № _____ -т

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Мэдээлэл технологийн үндэсний парк ТӨААТҮГ-ын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Мэдээлэл технологийн үндэсний парк ТӨААТҮГ-ын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан материаллаг алдаагүй, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад, нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллага олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 8 зорилтын хүрээнд 33 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 93.6 хувийн гүйцэтгэлтэй байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд удирдлагын хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, холбогдох журам зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхийн аудитын тайлан гаргах зорилготой.


Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ



2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

		/төгрөгөөр/	
Мөрийн дугаар	Үзүүлэлт	2019 оны 12-р сарын 31	2020 оны 12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	66,470,905.00	21,698,550.84
1.1.2	Дансны авлага	189,982,106.83	228,882,367.91
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага	0.00	0.00
1.1.4	Бусад авлага	0.00	0.00
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө	0.00	0.00
1.1.6	Бараа материал	70,229,431.80	80,168,470.82
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	9,570,992.70	1,052,080.00
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө	0.00	0.00
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	336,253,436.33	331,801,469.57
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	2,969,514,691.73	2,836,213,516.77
1.2.2	Биет бус хөрөнгө	673,280,000.00	673,280,000.00
1.2.3	Биологийн хөрөнгө	0.00	0.00
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт	0.00	0.00
1.2.5	Хайгуул ба үнэлгээний хөрөнгө	0.00	0.00
1.2.6	Хойшлогдсон татварын хөрөнгө	0.00	0.00
1.2.7	Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө	0.00	0.00
1.2.8	Бусад эргэлтийн бус хөрөнгө	0.00	0.00
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	3,642,794,691.73	3,509,493,516.77
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	3,979,048,128.06	3,841,294,986.34
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	Өр төлбөр		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	97,447,426.58	100,278,326.58
2.1.1.2	Цалингийн өглөг	0.00	0.00
2.1.1.3	Татварын өр	196,260,509.83	143,489,822.47
2.1.1.4	НДШ - ийн өглөг	0.00	0.00
2.1.1.5	Богино хугацаат зээл	0.00	0.00
2.1.1.6	Хүүний өглөг	0.00	0.00
2.1.1.7	Ногдол ашгийн өглөг	0.00	0.00
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	6,233,550.00	37,041,000.00
2.1.1.9	Нөөц/өр төлбөр/	0.00	0.00
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	0.00	0.00
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	299,941,486.41	280,809,149.05
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.1	Урт хугацаат зээл	4,901,102.15	4,370,825.15
2.1.2.2	Нөөц /өр төлбөр/	0.00	0.00
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр	0.00	0.00
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр	0.00	0.00
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	4,901,102.15	4,370,825.15

Мэдээлэл технологийн үндэсний парк ТӨААТҮГ-ын 2020 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2.2	Өр төлбөрийн нийт дүн	304,842,588.56	285,179,974.20
2.3	Эздийн өмч		
2.3.1	Өмч:-төрийн	1,021,630,200.00	1,021,630,200.00
2.3.2	хувийн	0.00	0.00
2.3.3	хувьцаат	0.00	0.00
2.3.4	Халаасны хувьцаа	0.00	0.00
2.3.5	Нэмж төлөгдсөн капитал	0.00	0.00
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	3,213,222,704.68	3,213,222,704.68
2.3.7	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	0.00	0.00
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	789,494,381.42	789,494,381.42
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(1,350,141,746.60)	(1,468,232,273.96)
2.3.11	Эздийн өмчийн дүн	3,674,205,539.50	3,556,115,012.14
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	3,979,048,128.06	3,841,294,986.34

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		2019 оны 12-р сарын 31	2020 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	1,102,741,075.22	909,568,979.12
2	Борлуулалтын өртөг	0.00	0.00
3	Нийт ашиг(алдагдал)	1,102,741,075.22	909,568,979.12
4	Түрээсийн орлого	803,723,484.55	603,762,885.15
5	Хүүний орлого	814,600.27	151,937.79
6	Ногдол ашгийн орлого	0.00	0.00
7	Эрхийн шимтгэлийн орлого	0.00	0.00
8	Бусад орлого	298,202,990.40	305,654,156.18
9	Борлуулалт, маркетингийн зардал	49,336,826.60	42,937,977.37
10	Ерөнхий ба удирдлагын зардал	887,205,300.22	802,225,693.80
11	Санхүүгийн зардал	0.00	0.00
12	Элэгдлийн зардал	181,477,305.16	182,912,103.36
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз	0.00	0.00
17	Бусад ашиг (алдагдал)	0.00	0.0
18	Татвар төлөхийн өмнөх ашиг(алдагдал)	(15,278,356.76)	(118,506,795.41)
19	Орлогын татварын зардал	81,460.03	15,193.79
20	Татварын дараах ашиг (алдагдал)	(15,359,816.79)	(118,521,989.20)
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(15,172,537.72)	(118,090,527.36)
23	Бусад дэлгэрэнгүй орлого	187,279.07	431,461.84
	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү	0.00	0.00
	Гадаад валютын ханшийн зөрүү олз	187,279.07	431,461.84
	Бусад олз (гарз)	0.00	0.00
24	Орлогын нийт дүн	(15,172,537.72)	(118,090,527.36)

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

						/төгрөгөөр/
Үзүүлэлт	Өмч	Нэмж төлөгдс өн капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2018 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	1,811,124,581.42	0.00	3,213,222,704.68	0.00	(1,334,969,208.88)	3,689,378,077.22
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	0.00	0.00	0.00	(15,172,537.72)	(15,172,537.72)
Өмчид гарсан өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
2019 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	1,811,124,581.42	0.00	3,213,222,704.68	0.00	(1,350,141,746.60)	3,674,205,539.50
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	0.00	0.00	0.00	(118,090,527.36)	(118,090,527.36)
2020 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	1,811,124,581.42		3,213,222,704.68	0.00	(1,468,232,273.96)	3,556,115,012.14

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	/төгрөгөөр/	
		2019 оны 12-р сарын 31	2020 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	1,046,220,970.01	939,352,494.17
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	808,451,405.82	569,432,703.50
	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	0.00	0.00
	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	6,158,988.00	6,120,426.00
	Буцаан авсан албан татвар	0.00	0.00
	Татаас, санхүүжилтийн орлого	0.00	0.00
	Бусад мөнгөн орлого	231,610,576.19	363,799,364.67
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	996,695,724.89	946,778,109.95
	Ажиллагчдад төлсөн	298,289,101.86	323,836,276.00
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	95,961,987.64	104,129,950.26
	Бараа материал худалдан авахад төлсөн	14,188,755.00	45,213,890.81
	Ашиглалтын зардалд төлсөн	144,169,221.98	129,664,822.59
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	6,581,100.00	4,496,400.00
	Газрын төлбөр	6,732,800.00	6,727,680.00
	Татварын байгууллагад төлсөн	134,233,580.61	166,564,756.33
	Даатгалын төлбөрт төлсөн	6,158,988.00	5,970,426.00
	Бусад мөнгөн зарлага	290,380,189.80	160,173,907.96
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	49,525,245.12	(7,425,615.78)
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	5,477,614.27	8,442,413.47
	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	0.00	0.00
	Биет бус хөрөнгө борлуулсны орлого	0.00	0.00
	Хөрөнгө оруулалт борлуулсны орлого	0.00	0.00
	Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого	0.00	0.00
	Бусад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	4,663,014.00	8,290,475.68
	Хүлээн авсан хүүний орлого	814,600.27	151,937.79
	Хүлээн авсан ногдол ашиг	0.00	0.00
		0.00	0.00
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	31,806,142.70	55,997,705.00
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	11,885,150.00	45,283,665.00
	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	0.00	0.00
	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	0.00	0.00

	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	0.00	0.00
	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	19,920,992.70	10,714,040.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(26,328,528.43)	(47,555,291.53)
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	15,086,350.00	11,981,174.37
	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	15,086,350.00	11,600,000.00
	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	0.00	0.00
	Төрөл бүрийн хандив	0.00	0.00
	Гадаад валютын ханшийн зөрүүний олз	0.00	381,174.37
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	1,624,250.00	1,772,621.22
	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	1,624,250.00	1,733,820.00
	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн	0.00	0.00
	Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн	0.00	0.00
	Төлсөн ногдол ашиг	0.00	0.00
	Гадаад валютын ханшийн зөрүүний олз	0.00	38,801.22
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	13,462,100.00	10,208,553.15
4	Валютын ханшийн зөрүү	(8,895.00)	0.00
5	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	36,649,921.69	(44,772,354.16)
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	29,820,983.31	66,470,905.00
7	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	66,470,905.00	21,698,550.84

2.5 Аудит хийсэн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

/сая төгрөг/

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2019 оны гүйцэтгэл	2020 он		Зөрүү	Хувь
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	2	3	4	5	6	7	8
1	Бүтээгдэхүүн үйлдвэрлэлт						
	Мэдээлэл технологийн сургалт	биет	78.2	241.9	56.3	(185.6)	23.2
	Инкубаторын үйл ажиллагаа	биет	1.3	306.5	170.5	(136.0)	55.6
	Төсөл хөтөлбөр	биет	218.4	267.6	240.9	(26.7)	90.0
	Түрээсийн үйлчилгээ	биет	773.9	653.4	583.7	(69.7)	89.3
	Бусад орлого	биет	31.1	34.6	25.9	(8.7)	74.9
2	Нийт орлого	сая төг	1,102.9	1,504.0	1,077.3	(426.7)	71.6
	Үүнээс: Цэвэр борлуулалт	сая төг	1,102.9	1,470.8	910.0	(560.8)	61.9
3	Нийт зардал	сая төг	1,118.1	1,500.9	1,028.1	(472.8)	68.5
	Үүнээс: Удирдлагын зардал	сая төг	78.3	86.1	83.9	(2.2)	97.4
4	Татварын өмнөх ашиг	сая төг	(15.2)	3.1	(118.1)	(115.0)	0.0
5	Цэвэр ашиг алдагдал	сая төг	(15.2)	2.8	(118.1)	(120.9)	0.0
6	Төсвийн төлбөрт	сая төг	236.9	165.1	296.8	131.7	180.0
7	Нийт ажиллагсадын тоо	хүн	34	43	38	5	
8	Нийт цалингийн сан	сая төг	340.4	451.6	370.4	(81.2)	82.0
9	Нэг ажилтаны дундаж цалин	сая төг	834.3	875.2	812.3	(62.9)	92.8
10	Борлуулалтын нэг төгрөгт ноогдох зардал	төгрөг	1.01	1.00	1.05	0.05	105.0
11	Хөрөнгө оруулалт	сая төг	0.00	175.2	44.3	(130.9)	25.3
12	Нийт авлага	сая төг	190.0	40.1	228.9	188.8	0.0
13	Нийт өглөг	сая төг	304.8	221.3	285.2	63.9	0.0

3. Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасан бүрэн эрхийн хүрээнд Мэдээлэл технологийн үндэсний парк ТӨААТҮГ-ын 2020 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг Захирал Э.Цогтгэрэл танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд анхан шатны маягт бүртгэлийг батлагдсан маягт аргачлалаар хөтөлж баталгаажуулж байх, санхүүгийн программд хөгжүүлэлт хийлгэх, бүрдэл дутуу баримтаар гүйлгээ хийхгүй байх зөвлөмжийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 02 дугаар сарын 25-наас 2021 оны 03 дугаар сарын 15-ны хооронд Үндэсний аудитын газрын захиалгаар Стандарт дүгнэлт аудит ХХК-ийн чанарын менежер Б.Наранцэцэг, аудитор А.Цэрэнчимэд, аудиторын туслах Ч.Мөнхбулган нар хариуцаж хэрэгжүүлэв.

Мэдээлэл технологийн үндэсний парк ТӨААТҮГ-ын 2020 оны санхүүгийн тайланг Үндэсний аудитын газарт 2021 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн 02/25 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар статустай, өмчийн 100 хувийг төр эзэмшиж байна.

Мэдээлэл технологийн үндэсний парк ТӨААТҮГ-ын дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Төр, хувийн хэвшил, эрдэм шинжилгээний байгууллагын хамтын ажиллагаанд суурилсан инновацийн тогтолцоог хөгжүүлэхэд хувь нэмэр оруулах.
- Мэдээлэл технологийн үндэсний компаниудыг төлөвшүүлэх, бойжуулах.
- Мэдээллийн технологийн өндөр ур чадвартай боловсон хүчнийг хөгжүүлэх.
- Мэдээлэл технологийн бодлого боловсруулахад дэмжлэг үзүүлэх.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- ТӨБЗГ-ын "Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн төлбөрийн доод хязгаар, түрээсийн зарим төлбөрийн хэмжээг тогтоох заавар, улсын төсөвт төвлөрүүлэх орлогын хувь хэмжээг шинэчлэх батлах тухай" 2020 оны 2 дугаар сарын 49 тоот тогтоол.

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Мэдээлэл технологийн үндэсний парк ТӨААТҮГ нь санхүүгийн тайлангаа Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Компанийн тухай хууль болон СТОУС, түүнд нийцүүлэн баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Тус байгууллагад дотоод аудит хийх чиг үүрэг бүхий нэгж, орон тоо байхгүй тул 2020 онд санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгдээгүй байна.

Тайлант онд тус байгууллагын 2020 санхүүгийн үйл ажиллагааг харьяалах дээд шатны байгууллагаас хяналт шалгалт хийгээгүй байна.

Мэдээлэл технологийн үндэсний парк ТӨААТҮГ-ын дотоод хяналтын эрсдлийг төлөвлөлтийн үе шатанд үр нөлөөтэй гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзэж аудитын горим сорилын цар хүрээг нэмэгдүүлж гүйцэтгэлээ.

3.4. Материаллаг байдал

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдлийн түвшинг "дунд" гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2019 оны жилийн орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлын 1,118.1 сая төгрөгөөс 1 хувиар буюу 11.2 сая төгрөгөөр тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд өөрчлөх шаардлагагүй гэж үзлээ.

3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Мэдээлэл технологийн үндэсний парк ТӨААТҮГ-ын 2020 оны санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 137.7 сая төгрөгөөр буюу 3.5 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	66.5	21.7	(44.8)
Авлага	190.0	228.9	38.9
Урьдчилгаа	9.6	1.0	(8.6)
Бараа материал	70.2	80.2	10.0
Үндсэн хөрөнгө	3,642.7	3,509.5	(133.2)
Нийт хөрөнгийн дүн	3,979.0	3,841.3	(137.7)
Өр төлбөр	304.8	285.2	(19.6)
Эздийн өмч	3,674.2	3,556.1	(118.1)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	3,979.0	3,841.3	(137.7)

Өмнөх оны үзүүлэлтээс мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн дансад материаллаг өөрчлөлт гарсан байна.

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 21.7 сая төгрөг болж 44.8 сая төгрөгөөр буурсан нь нь 19.6 сая төгрөгийн татварын өрийг барагдуулсан, 2019 онд хийхээр төлөвлөсөн засварын ажил хойшлогдсоноос 25.2 сая төгрөгийн ажлын хөлс 2020 оны 1 дүгээр сард гарсантай холбоотой байна.

Авлага дансны үлдэгдэл 228.9 сая төгрөг болж 38.9 сая төгрөгөөр өссөн нь ковид 19 цар тахалтай холбоотой түрээслэгч байгууллагын түрээсийн төлбөр төлөгдөөгүйгээс шалтгаалжээ. Авлага дансны үлдэгдэлд 2009-2015 онуудад үүссэн, он удаан жил болсон 62.9 сая төгрөгийн байгууллагаас авах авлага байна.

Нийт авлагаас 16 байгууллагатай холбоотой 14.4 сая төгрөгийн авлагыг шүүхэд өгсөн боловч маргаантай, шийдэгдээгүй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 80.2 сая төгрөг болж 2.3 сая төгрөгийн ном, 7.7 сая төгрөгийн хангамжийн материал худалдан авч үлдэгдэлтэй гарсанаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 3,509.5 сая төгрөг болж 133.2 сая төгрөгөөр буурсан нь ТӨБЗГ-ын 2020 оны 7 дугаар сарын "Үндсэн хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай" 349 тоот тогтоолоор үнэ төлбөргүй шилжиж ирсэн 5.3 сая төгрөг, өөрийн хөрөнгөөр худалдан авсан 44.3 сая төгрөгийн хөрөнгөөр нэмэгдэж, ТӨБЗГ-ын 2019 оны 10 дугаар сарын 16-ны А 1/3527 тоот зөвшөөрлийг үндэслэн 2.0 сая төгрөгийн хөрөнгийг акталсан дүнгээр хасагдсан байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 285.2 сая төгрөг болж 19.2 сая төгрөгөөр буурсан нь татварын өрийг барагдуулсан нь шалтгаалжээ.

Урт хугацаат өр төлбөр 2010 онд үүссэн 4.4 сая төгрөгийн өр байна. Энэ нь 2010 онд УБ дулааны сүлжээ ТӨХК-тай байгуулсан дулааны үр ашгийн төсөлд олгосон урт хугацаат зээл байна. Зээлийн төлбөр хуваарийн дагуу төлөгдөж байна.

Бусад 280.8 сая төгрөгийн өр нь 143.5 сая төгрөг татварын, 30.0 сая төгрөг түрээсийн барьцааны, 37.1 сая төгрөг бусад байгууллагад өгөх, 70.2 сая төгрөг ТӨБЗГ-т төлөх түрээсийн орлогоос төвлөрүүлэх өр төлбөр тус тус байна. Хуримтлагдсан татвар болон түрээсийн орлогоос төвлөрүүлэх өр төлбөр нь 2014-2015 онуудад үүссэн 213.7 сая төгрөгийн өр төлбөр байна.

Эздийн өмч дансны үлдэгдэл 3,556.1 сая төгрөг болж 118.1 сая төгрөгөөр буурсан нь тайлант оны алдагдлаас шалтгаалжээ.

Төрийн өмчийн дансны 1,021.6 сая төгрөгийн үлдэгдэл тайлант хугацаанд өөрчлөлт гараагүй байна

Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл дансны 3,213.2 сая төгрөгийн үлдэгдэл тайлант хугацаанд өөрчлөлт гараагүй байна.

Эздийн өмчийн бусад хэсэг дансны 789.5 сая төгрөгийн үлдэгдэл тайлант хугацаанд өөрчлөлт гараагүй байна.

Өмнөх үеийн хуримтлагдсан алдагдал 1,468.2 сая төгрөг болж 118.1 сая төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант оны алдагдлаас шалтгаалжээ.

3.6. Зорилтот түвшний төлөвлөлт, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 1.3-д заасны дагуу Мэдээлэл технологийн үндэсний парк ТӨААТҮГ-ын захирал нь байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

ТӨБЗГ-ын 2019 оны 12 дугаар сарын 546 дугаар тогтоолоор Мэдээлэл технологийн үндэсний парк ТӨААТҮГ-ын 2020 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан байна. Тайлант оны нийт орлогыг 1,504.0 сая төгрөгөөр, нийт зардлыг 1,500.9 сая төгрөгөөр, ашгийг 3.1 сая төгрөгөөр баталсан байна. Үүнээс хөрөнгө оруулалтын 4 арга хэмжээнд 175.1 сая төгрөгийг төлөвлөсөн байна.

Мэдээлэл технологийн үндэсний парк ТӨААТҮГ-ын 2020 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Гүйцэтгэлээр 910.0 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 1,028.1 сая төгрөгийн зардал гарган, 118.1 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна. Орлогын эх үүсвэр нь түрээсийн орлого 583.7 сая төгрөг, төсөл хөтөлбөр 240.9 сая төгрөг, инкубаторын болон сургалтын орлого.85.4 сая төгрөгөөс тус тус бүрджээ.

Хүснэгт 1. 2020 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин

/сая төгрөг/

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2019 оны гүйцэтгэл	2020 оны		Зөрүү	Хувь
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Үйлдвэрлэлийн үндсэн үзүүлэлт						
	Түрээсийн орлого	биет	773.9	653.4	583.7	(69.7)	89.3
	Төсөл хөтөлбөр	биет	218.4	267.6	240.9	(26.7)	90.0
	Мэдээлэл технологийн сургалт	биет	78.2	241.9	56.3	(185.6)	23.3
	Инкубаторын үйл ажиллагааны орлого	биет	1.3	306.5	170.5	(136.0)	55.6
	Бусад орлого	биет	31.1	34.6	25.9	(8.7)	74.9
2	Нийт орлого	сая төг	1,102.9	1,504.0	1,077.3	(426.7)	71.6
	Үүнээс: Цэвэр борлуулалт	сая төг	1,102.9	1,470.8	910.0	(560.8)	61.9
3	Нийт зардал	сая төг	1,118.1	1,500.9	1,028.1	(472.8)	68.5
	Үүнээс:	сая төг	0.00	0.00	0.00	0.00	0.0
	а)Борлуулсан бүтээгдэхүүний өртөг						
	б) Ерөнхий ба удирдлагын зардал	сая төг	78.3	86.1	83.9	(2.2)	97.4
	в) Хөрөнгө оруулалт их засвар	сая төг	0.00	175.2	44.3	(130.9)	25.3
4	Цэвэр алдагдал ашиг,	сая төг	-15.2	3.1	(118.1)	(115.0)	0.0

Нийт орлогын гүйцэтгэл 1,077.3 сая төгрөг болж төлөвлөснөөс 426.7 сая төгрөг буюу 28.4 хувиар тасарчээ. Энэ нь Ковид-19 цар тахалтай холбоотой мэдээлэл технологийн сургалт цуцлагдсанаас 185.6 сая төгрөг, түрээслэгч байгууллагын орлого буурснаас 69.7 сая төгрөг, инкубаторын орлого 171.4 сая төгрөгөөр тус тус тасарсан байна.

Нийт зардлын гүйцэтгэл 1,028.1 сая төгрөг болж, төлөвлөснөөс 472.8 сая төгрөг буюу 31.5 хувиар дутуу гүйцэтгэлтэй байна. Энэ нь цалингийн зардал 81.2 сая төгрөг, үндсэн сургалтын зардал 79.4 сая төгрөг, инкубаторын зардал 232.2 сая төгрөг, төсөл хөтөлбөрийн зардал 26.9 сая төгрөг бусад үйл ажиллагааны зардал 53.1 сая төгрөгөөр дутуу зарцуулагдсан байна. Энэ нь цалингийн зардлын хэмнэлт батлагдсан орон тоо 5 хүнээр дутуу ажилласантай, Ковид 19 цар тахалтай холбоотойгоор сургалтын болон төсөл хөтөлбөрүүд цуцлагдсан зэрэг нь гол нөлөө үзүүлсэн байна.

Батлагдсан хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний дагуу байрны урсгал засварын зардалд өөрийн эх үүсвэрээс 44.3 сая төгрөгийн зардлыг санхүүжүүлсэн байна.

Тайлант онд цэвэр алдагдал 118.1 сая төгрөг болж, төлөвлөснөөс 115.0 сая төгрөгөөр дутуу байна. Энэ нь Ковид-19 цар тахалын нөлөөгөөр зорилтот түвшинд төлөвлөгдсөн 2020 оны 11,12 дугаар сард зохион байгуулагдах байсан сургалт цуцлагдсанаас 52.3 сая төгрөг, түрээслэгч байгууллагын түрээсийн төлбөрийг 30 хувиар бууруулсанаас 69.7 сая төгрөгөөр тус тус орлого буурсан, үл хөдлөх хөрөнгийн элэгдлийн

зардал 182.9 сая төгрөг гарсан зэргээс шалтгаалж алдагдалтай ажиллажээ. Тус байгууллага 2020 оны зорилтот түвшинд тодотгол хийгээгүй байна.

Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг үйлдвэрлэлийн үндсэн үзүүлэлт, орлого, зардлын зүйлс тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.7. Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн, үйл ажиллагаа

Тус байгууллагын нийт өмчийн 100 хувийг төр эзэмшиж байгаа тул төлөөлөн удирдах зөвлөл байгуулаагүй байна.

3.8. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд оруулбал зохих 104 мэдээллээс 100 мэдээллийг хугацаанд нь, 29.9 сая төгрөгийн 4 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

3.9. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт дараах байдалтай байна.

Хүснэгт 2. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/сая.төгрөг

Үзүүлэлт	Өмнөх илрүүлэлт оны		Биелэлт		Гүйцэтгэлийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Акт					
Албан шаардлага	1	6.7	1	0.00	0.0
Зөвлөмж	2	36.5	2	36.5	100.0
Нийт дүн	3	43.2		36.5	50.0

Өмнөх аудитаар өгсөн 6.7 сая төгрөгийн авлагыг барагдуулах албан шаардлагын хэрэгжилт биелээгүй байна. Дээрх авлагыг барагдуулахаар шүүхэд нэхэмжилсэн боловч шийдэгдээгүй, шүүхийн шатанд байна.

3.10. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 4.3 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 3.8 сая төгрөгийн зөрчилд 1 акт тогтоож, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах 1 албан шаардлага хүргүүлж, 0.5 сая төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өглөө.

Төлбөрийн акт, албан шаардлага

1.Улсын төсөвт төвлөрүүлэх 3.8 сая төгрөгийн түрээсийн орлогыг дутуу төвлөрүүлсэн. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 5-д “Төрийн өмчийн түрээсийн төлбөрийг улсын төсөвт оруулна”, Төрийн өмчийн хорооны 2014 оны 6 дугаар сарын “Шалгалтын мөрөөр авах арга хэмжээний тухай” 363 дугаар тогтоолын 3 дахь хэсгийн в-гийн “Төрийн өмчийн хорооны зөвшөөрлийг үндэслэн түрээсийн орлогыг 10 хувиар тооцон төвлөрүүлэх” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоох

2. Шилэн дансны цахим хуудсанд 4 мэдээлэл хугацаа хоцроосон. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”, 4.1.3-т “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх

3.11. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд

Дараагийн аудитаар дараах асуудлыг авч үзэх нь зүйтэй.

- Түрээсийн гэрээ, түрээсийн орлогоос улсын төсөвт төвлөрүүлэх орлого
- Өглөг, авлагын барагдуулалт.
- Тус байгууллага 2020 онд 3.1 сая төгрөгийн ашигтай ажиллахаар төлөвлөсөн боловч Ковид-19 цар тахалаас шалтгаалж 118.1 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.
- Байгууллагын зорилтот түвшний үзүүлэлтийг бодитой төлөвлөж батлуулдаг байх
- Батлагдсан үзүүлэлтийг биелүүлэх боломжгүй болсон нөхцөлд эрх бүхий байгууллагад шалтгаан тайлбарыг тухай бүр хүргүүлж, тодотгол хийлгэж байх.

4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Балансын данстай холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт: Батлагдсан анхан шатны маягт, аргачлалаар бүртгэл хөтөлж, баталгаажуулаагүй, бүрдэл дутуу баримтаар 0.5 сая төгрөгийн ажил гүйлгээ хийсэн. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7. "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Сангийн сайдын 2017 оны "Маягт, заавар батлах тухай" 347 дугаар тушаалын заалтуудтай нийцэхгүй, "Үнэн зөв" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

1.2 Эрсдэл: Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Сангийн сайдын 2017 оны 247 дугаар тушаалыг хэрэгжүүлээгүй, дотоод хяналт сул

1.3 Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалыг хэрэгжүүлж санхүүгийн програмд өөрчлөлт хийлгэх, дотоод хяналтыг сайжруулах.

1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хуулийн хэрэгжилтийг хангаж, шинэчилсэн анхан шатны маягтыг хөтөлж, санхүүгийн програм хангамжинд өөрчлөлт хийлгэнэ.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.